

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

2010 он 01 дүгээр
сарын 27 -ны өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын дүн, илэрсэн зөрчил дутагдлын талаар Хорооны гишүүн, улсын ахлах байцаагч Д.Дүгэржав танилцуулав.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын дүн, болон гарсан зөрчил дутагдал, мөн “Монголын хөрөнгийн бирж” ХК болон Хорооны зүгээс авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар сонсч, танилцан дараах үүргүүдийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Гүйцэтгэх захирал Р.Содхүү/-д өгөхөөр тогтов:

1. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар Хорооноос өгсөн үүрэг даалгаврыг тогтоосон хугацаанд биелүүлж, биелэлтийг нэгтгэн тайлагнах;

2. Эргэлтийн хөрөнгө, эрсдэлийн сангийн хэмжээг Хорооны 2006 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журамд”-д заасан хэмжээнд хүргэх, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 19.2.11-д заасны дагуу эрсдэлийн санг байгуулж, 2010 оны жилийн эцсийн баланст тусган ажиллах;

3. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн холбогдох заалт зөрчсөн үйлдэлд гэрээний заалт зөрчсөн гэсэн үндэслэлээр биржийн байцаагч торгууль ногдуулж байгааг таслан зогсоох, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 19.2.4-д зааснаар “өөрийн гишүүн болон үнэт цаас гаргагч, бусад оролцогч этгээд хууль тогтоомж зөрчсөн тухай мэдээллийг Хороонд хүргэх” үүргээ биелүүлэн ажиллах;

4. Монголын хөрөнгийн биржийн хяналтын албаны үйл ажиллагааг сайжруулах, үнэт цаасны зах зээлийн хяналт, биржийн ажилтнууд, тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээдүүд дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцож байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж байх, хяналтын тайланг улирал бүр Хороонд ирүүлж ажиллах;

5. Хорооны 2006 оны 29 дүгээр тогтоолоор баталсан Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журмын 2.1.4-д заасан тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг хангаж, Хорооноос эрх авсан ажилтнуудыг ажиллуулах, холбогдох ажилтнуудыг сургалтад хамруулах;

6. Хорооны шийдвэрээр үнэт цаасны бүртгэлээс хасагдаж буй компанийг Монголын хөрөнгийн биржийн бүртгэлээс нэн даруй хасаж, тогтоолын биелэлтийг тайлагнахыг Хороонд шуурхай тайлагнаж ажиллах;

7. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн охин компани болох “MSEK” ХХК-ийн интернэт кафены үйл ажиллагааг зогсоох;

8. Бүртгэлтэй хувьцаат компанийн хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон вэб хуудсаар дамжуулан долоо хоногийн давтамжтай шинэчлэн зарлах замаар олон нийтийг мэдээллээр ханган ажиллах;

9. Хувьцаат компанийн бүртгэлийн шаардлага хангаж буй эсэхэд үндэслэн арилжааг ангилан явуулах бэлтгэлийг 2010 оны эхний улиралд багтаан хангаж, арилжааг ангилан явуулах горимыг 2010 оны 4 дүгээр сард багтаан нэвтрүүлэх;

10. ТУЗ-ийн үйл ажиллагааг хэвийн явуулах, ТУЗ-ийн гишүүдийг Компанийн тухай хуулийн 75.3-д заасан шаардлагад нийцүүлэн батлах, ТУЗ-ийн гишүүний бүрэлдэхүүнд биржийн гишүүн брокер дилерийн компаниудын төлөөллийг оруулах.

2. Тэмдэглэлээр өгсөн үүргийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/-д даалгахаар тогтов.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН